

ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ИРГЭДИЙН
ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ, САНАЛ, ХҮСЭЛТИЙН
ДӨРӨВДҮГЭЭР УЛИРЛЫН ТАЙЛАН

2023 оны 12 дүгээр сарын 28

Улаанбаатар хот

НЭГ. ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ ШИЙДВЭРЛЭЛТИЙН ТАЛААР

Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/1049 дугаар захирамжаар батлагдсан “Нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд хандсан өргөдөл гомдлыг шийдвэрлэх журам”-ыг мөрдөж, өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийг эрчимжүүлэх, шийдвэрлэлтийн дундаж хугацааг зорилтод түвшинд хүргэхээр зорин ажиллаж байна.

2023 оны 12 дүгээр сарын 25-ны өдрийн байдлаар дүүргийн хэмжээнд нийт 5776 өргөдөл, гомдол ирсэн. Үүнээс судлагдаж байгаа 58, хуулийн хугацаанд 5679, хугацаа хэтрүүлэн 39 өргөдөл, гомдлыг шийдвэрлэсэн. Шийдвэрлэлтийн дундаж хугацаа 2023 оны 12 дүгээр сарын 25-ны өдрийн байдлаар 07 хоног 11 цаг 19 минут байна.


Үүнээс Засаг даргын Тамгын газарт 950 өргөдөл, гомдол ирүүлснээс судлагдаж байгаа 8, хуулийн хугацаанд шийдвэрлэсэн 940, хугацаа хэтрүүлэн шийдвэрлэсэн 2 өргөдөл, гомдол байна. Шийдвэрлэлтийн дундаж хугацаа 2023 оны 12 дүгээр сарын 25-ны өдрийн байдлаар 08 хоног 05 цаг 23 минут байна.

Хан-Уул дүүрэг	Нийт өргөдөл		Хуулийн хугацаанд шийдвэрлэсэн		Хугацаа хэтэрч шийдвэрлэсэн		Шийдвэрлэлтийн дундаж хоног		Зөрчлийн тоон үзүүлэлт	
	2022 XII/25	2023 XII/25	2022 XII/25	2023 XII/25	2022 XII/25	2023 XII/25	2022 XII/25	2023 XII/25	2022 XII/25	2023 XII/25
ИТХ	9	3	6	1	2	2	18х 19ц 35м	32х 23ц 16м	62	68
Засаг даргын Тамгын газар	868	950	859	940	2	2	06х 08ц 38м	08х 05ц 23м	63	67
Харьяа хэлтэс, алба, тасаг	3826	3521	3703	3461	42	23	08х 03ц 08м	08х 08ц 07м	1174	575
Дүүргийн өмчит үйлдвэрийн газрууд	51	72	49	69	2	1	06х 14ц 19м	08х 17ц 12м	158	50
Хороод	341	529	320	515	19	11	06х 07ц 57м	06х 15ц 41м	572	654
Эмнэлэг	534	670	522	662	7		05х 08ц 31м	02х 11ц 14м	265	125
Цэцэрлэг, сургууль	16	31	16	31			02х 10ц 09м	02х 05ц 57м	2	15
НИЙТ	5645	5776	5475	5679	74	39	07х 11ц 11м	07х 11ц 19м	2296	1554

ХУУЛИЙН ХУГАЦАА ХЭТЭРСЭН ШИЙДВЭРЛЭЛТ:



ТӨРЛӨӨР АНГИЛЖ ҮЗВЭЛ:



ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР


НЭГЖҮҮД	ШИЙДВЭРЛЭСЭН						Шийдвэрлэлтийн дундаж хугацаа		Зөрчлийн тоон үзүүлэлт	
	Хугацаандаа шийдвэрлэсэн		Хугацаа хэтэрсэн		Нийт					
	2022 XII/25	2023 XII/25	2022 XII/25	2023 XII/25	2022 XII/25	2023 XII/25	2022 XII/25	2023 XII/25	2022 XII/25	2023 XII/25
Удирдлага	2	11	0	0	4	12	13x01 ц 58м	10x09 ц 17м	20	8
Төрийн захиргааны удирдлагын хэлтэс	124	176	1	1	125	177	00x11 ц 24м	07x06 ц 03м	9	14
Санхүү, төрийн сангийн хэлтэс	2	6	1	0	3	6	15x06 ц 29м	05x21 ц 53м	1	0
Нийгмийн хөгжлийн хэлтэс	44	24	0	0	44	24	05x13 ц 43м	13x11 ц 43м	4	4
Төлөвлөлт гүйцэтгэлийн удирдлагын хэлтэс	85	53	0	0	85	53	06x10 ц 07м	10x12 ц 18м	6	3

Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс	205	408	0	0	210	413	07x21 ц 00м	08x03 ц 28м	7	21
Агаарын бохирдолтой тэмцэх тасаг	188	-	0	-	188	-	06x14 ц 37м	-	9	0
Хүнс, худалдаа, үйлчилгээний хэлтэс	67	184	0	1	67	187	08x14 ц 51м	09x22 ц 17м	5	7
Цэргийн штаб	103	54	0	0	103	54	00x10 ц 16м	01x00 ц 29м	0	4
Хууль, эрх зүйн хэлтэс	31	20	0	0	31	20	05x23 ц 42м	09x07 ц 31м	0	6
Аж, ахуй, өмчийн хэлтэс	4	1	0	0	4	1	13x02 ц 09м	12x01 ц 54м	1	0
Хэвлэл, мэдээллийн тасаг	4	3	0	0	4	3	10x15 ц 01м	01x14 ц 02м	1	0
НИЙТ ДҮН	859	940	2	2	868	950	06x08 ц 38м	09x05 ц 23м	63	67
ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ ШИЙДВЭРЛЭЛТИЙН ИНДЕКС									0.857	

ШИЙДВЭРЛЭХ ЯВЦАД ГАРГАСАН ЗӨРЧЛИЙН ТӨРӨЛ, БАЙГУУЛЛАГААР:

Зөрчлийн төрөл	Зөрчлийн тоо	Байгууллагаар	Зөрчлийн тоо
Бусад зөрчил	0	Иргэдийн төлөөлөгчдийн хурал	68
Явцын тэмдэглэл хөтлөөгүй зөрчил	223	Засаг даргын Тамгын газар	67
Өдөрт нь багтаан шилжүүлээгүй зөрчил	216	Харьяа хэлтэс, алба, тасаг	575
Өдөрт нь багтаан хүлээн аваагүй зөрчил	1086	Дүүргийн өмчит үйлдвэрийн газрууд	50
Буцаалтыг 3 хоногт багтаан хийгээгүй зөрчил	29	Хороод	654
Холбогдох файл хавсаргаагүй	0	Эмнэлэг	125
НИЙТ	1554	Сургууль, цэцэрлэг	15
		Дүүргийн хэмжээнд/нийт/	1554

Зөрчлийн тоог өмнөх оны мөн үетэй харьцуулбал:



**ХОЁР.ИРГЭДЭЭС НУТГИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГА, АЛБАН
ТУШААЛТАНД ХАНДАЖ ГАРГАСАН ХҮСЭЛТ, ГОМДЛЫГ БУУРУУЛАХ
ЧИГЛЭЛЭЭР ХИЙСЭН АЖЛЫН БИЕЛЭЛТ**


1. Орон сууцны 1 давхарт байрлах үйлчилгээний газруудын тухай.

Хүн амыг эрүүл аюулгүй хүнсээр хангах, хоолны илчлэг шим тэжээллэг чанарыг сайжруулах, хүнсний эрүүл ахуй, стандартын шаардлага хангасан үйлдвэрлэл, үйлчилгээг нэмэгдүүлэх, ажилтан албан хаагчдын ур чадварыг сайжруулах зорилгоор мэргэжлийн байгууллагуудтай хамтран 6 удаагийн сургалтыг зохион байгуулж, хоол үйлдвэрлэл, аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй 334 иргэн, аж ахуйн нэгжийн давхардсан тоогоор нийт 640 ажилтан албан хаагчдыг хамруулсан.



2. Түргэн үйлчилгээний цэг, ил задгай худалдаа эрхлэгчдийн үйл ажиллагааны талаар

Дүүргийн Засаг даргын 2023 оны “Газрын зөрчил арилгаж, нүүлгэн шилжүүлэх арга хэмжээ авах тухай” А/202, А/545 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд нийтийн эзэмшлийн зам талбай, автобусны буудалд явган хүний болон хөгжлийн бэрхшээлтэй хүний зам хааж, ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн орчимд зөвшөөрөлгүй байршуулсан 94 түргэн үйлчилгээний цэгийг дүүргийн Газар зохион байгуулалтын албатай хамтран нүүлгэн шилжүүлж, газар чөлөөлж ажилласан.



Дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын 2023 оны “Хан-Уул дүүргийн нутаг дэвсгэрт ил задгай, зөвшөөрөлгүй, худалдаа, үйлчилгээ явуулж буй иргэний үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх” удирдамжаар Нийслэлийн хүнс, хөдөө аж ахуйн газар, дүүрэг дэх Цагдаагийн газар, Мал эмнэлгийн тасаг, хороодтой хамтарсан ажлын хэсэг 6 удаагийн хяналт шалгалт хийж, зөрчлийг тухай бүр арилган, 2 иргэнд тус бүр 20 нэгжийн

торгуулийн арга хэмжээ авч, хүнсний аюулгүй байдлыг хангуулан, зөвлөн тусалж ажилласан.



3. СӨХ-ийн үйл ажиллагаатай холбоотой гомдлыг бууруулах чиглэлээр

Сууц өмчлөгчдийн холбоодоос ирүүлсэн хүсэлтийн дагуу шинээр 24 холбоог бүртгэж, 150 гэрчилгээний хугацааг сунгаж, гэрчилгээнд нэмэлт өөрчлөлт оруулсан бөгөөд 2023 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн байдлаар бүртгэлтэй 324 сууц өмчлөгчдийн холбоо үйл ажиллагаа явуулж байна.

Зураг . СӨХ, иргэдэд хуулийн дагуу зөвлөгөө, мэдээлэл өгч ажилласан байдал



Сууц өмчлөгчдийн холбоодын бүртгэл, мэдээллийг шинэчлэн, хог хаягдлын цэвэрлэгээ, үйлчилгээг сайжруулах, иргэдийн эрүүл аюулгүй, цэвэр орчинд ажиллаж амьдрах орчин нөхцөлийг бүрдүүлэх чиглэлээр Засаг даргын Тамгын газар, хороо, сууц өмчлөгчдийн холбоодын хамтын ажиллагааны гурвалсан гэрээг байгуулж, үүрэгжүүлэн ажиллаж байна. Дүүргийн хэмжээнд бүртгэлтэй нийт 308 СӨХ-той гэрээ байгуулахаас 2023 онд нийт 56 СӨХ-той гэрээ шинэчлэн байгуулсан байна.

4. Явган хүний зам талбайн тохижилт, гэрэлтүүлэгтэй холбоотой гомдлыг бууруулах чиглэлээр хийх ажлын төлөвлөгөө

Явган хүний зам талбайн засвар шинэчлэлтийн ажлын хүрээнд дүүргийн төсөв, дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 1, 2, 3, 11, 15, 19, 20, 22, 23, 24 дүгээр хорооны 19 байршилд нийт 10.6 км явган хүн зам талбайн засвар, шинэчлэлтийн чиглэлээр 7 төсөл арга хэмжээ хэрэгжихээр төлөвлөгдсөнөөс 2023 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн байдлаар 2 төсөл арга хэмжээ тендер зарлагдсан, 2 төсөл арга хэмжээ үнэлгээний шатанд, 3 төсөл арга хэмжээ хийгдэж байна.

Дүүргийн төсвийн хөрөнгөөр Наадамчдын зам дагуу 41 дүгээр сургуулийн харалдаа явган хүний гарцаас далан руу гарах явган шат, гүүрэн байгууламжийн ажлыг хэрэгжүүлж, ашиглалтад оруулсан.

Зураг. Хан-Уул дүүрэг, 5 дугаар хороо, Наадамчдын зам дагуу явган шат хийх ажлын явц



Дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн 2023 оны 1.0 тэрбум хөрөнгөөр гэр хороолол, орон сууц хороололд шинээр 360 ширхэг гэрэлтүүлэг шинээр суурилуулах ажил худалдан авах ажиллагааны шалгаруулах шатанд хэрэгжиж байна.

Дүүргийн орон сууц хороолол, гэр хорооллын гэрэлтүүлгийн засвар үйлчилгээнд тогтмол хяналт тавьж ажиллаж байна. Гэрэлтүүлгийн засвар үйлчилгээний ажлын хүрээнд 3 дугаар сард 198 ширхэг гэрэлтүүлэг, 39 ширхэг хазайж далийсан шон засварлаж, 816 метр агаарын сиб кабелиг шинээр татаж, 19 ширхэг гэрэлтүүлгийн самбарт засвар үйлчилгээ хийсэн. Иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх ажлын хүрээнд Ажилчны гудамж, Үйлдвэрийн гудамж дагуу таггүй 35, Наадамчдын зам дагуу 85 гэрэлтүүлгийн шонгийн тагжуулж, ил гарсан 311 метр кабелийг цэгцэлж булж, орчны аюулгүй байдлыг хангасан. Гэрэлтүүлгийн асалт 99.1 хувьтай байна.

Дүүргийн төсвийн хөрөнгө, дүүргийн орон нутгийн хөгжлийн сан, тохижилт, засвар шинэчлэлтийн зардлын 3,680.6 сая төгрөгийн хөрөнгөөр явган хүний замыг засварлаж шинэчлэх чиглэлээр 9 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөгдсөнөөс 2023 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн байдлаар 1, 2, 3, 11 дүгээр хорооны 12 байршлын 8574.9 м.кв талбайг засварлаж шинэчлэх 3 төсөл арга хэмжээ дуусаж, ашиглалтад хүлээж авах шатанд, 22, 23, 24 дүгээр хорооны 4 байршлын 7485 м.кв талбайг засварлаж шинэчлэх 3 төсөл арга хэмжээ гүйцэтгэлийн шатанд, 2, 3, 11, 15, 17, 19, 20 дугаар хорооны 14 байршлын 12868.0 м.кв талбайг засварлаж шинэчлэх 3 төсөл арга хэмжээ худалдан авах ажиллагааны шатанд тус тус хэрэгжиж байна.

Явган хүний зам талбайн засвар, шинэчлэлтийн засвар, шинэчлэлтийн ажлын хүрээнд төлөвлөгдсөн 28927.99 м.кв талбайгаас 34 хувь буюу 9835.5 м.кв талбайд шинээр, 66 хувь буюу 19092.5 м.кв талбайд стандартын шаардлага хангахгүй явган хүний зам талбайг шинэчилж байна. Үүнд:

Бүдүүвч. Хан-Уул дүүргийн нийтийн эзэмшлийн гудамж, талбайн явган хүний зам талбайн засвар, шинэчлэлтийн ажлын явц, хураангуй

/1-р хороо, 7, 26-р байрнаас 1-р хорооны байр хүртэл /902 м.кв талбай/






/1-р хороо, 41-р байрны гадна /135 м.кв/



/1-р хороо, 53-р цэцэрлэгийн урд /112.5 м.кв/



/2-р хороо, 12а 12б 12в байр орчимд /684 м.кв/



/2-р хороо, 8а байрны гадна талбай /300 м.кв/



/2-р хороо, 4-р байрны зүүн тал /326 м.кв/



/3-р хороо, 1а байрнаас урагш 50-р байр хүртэл /608 м.кв/



/1, 2 дугаар хороо, Жаргалант үйлчилгээний төвөөс 67-р цэцэрлэг хүртэл авто зам дагуух явган хүний замын засвар, шинэчлэлт /1146 м.кв/



/1, 2, 3-р хороо, Дунд голын авто замын хойд талын явган хүний замын засвар, шинэчлэлт/

Дүүргийн төсөв, дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн 1.59 тэрбум төгрөгийн хөрөнгөөр 2, 5, 8, 9, 10, 11, 12, 13, 14, 16, 21, 23, 24 дүгээр хороодын нийтийн эзэмшлийн гудамж талбайд **526 ширхэг гэрэлтүүлэг** шинээр суурилуулах 3 төсөл арга хэмжээ худалдан авах ажиллагааны шатанд хэрэгжиж байна. Үүнд:

➤ Дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн 2023 оны 1.0 тэрбум хөрөнгөөр 2, 5, 8, 9, 10, 11, 12, 13, 14, 16, 21, 23, 24 дүгээр хороодын нийтийн эзэмшлийн гудамж талбайд 360 ширхэг гэрэлтүүлэг шинээр суурилуулах ажлын тендер 2023 оны 08 дугаар сарын 11-ний өдөр нээж, 8 аж ахуй нэгж материал ирүүлсэн ч тендерийн шаардлага хангасан тендер ирээгүй тул татгалзсан.

➤ Нийтийн эзэмшлийн гудамж талбайн гэрэлтүүлгийн ажил (13 дугаар хороо)-ын гүйцэтгэгч шалгаруулах тендер 2023 оны 09 дүгээр сарын 08-ны өдөр нээсэн, үнэлгээ хийгдэж байна.

➤ Наадамчдын авто замаас Нүхт чиглэлийн авто замын гэрэлтүүлгийн ажил (23 дугаар хороо)-ын гүйцэтгэгчийг шалгаруулж, гэрээ байгуулах зөвлөмж өгсөн.


5. Гэрэлтүүлгийн засвар, үйлчилгээний гомдлын чиглэлээр:

Дүүргийн орон сууц хороолол, гэр хорооллын гэрэлтүүлгийн засвар үйлчилгээнд тогтмол хяналт тавьж ажиллаж байна. Гэрэлтүүлгийн засвар үйлчилгээний ажлын хүрээнд 2023 оны байдлаар 3975 метр кабель шугам, 712 ширхэг гэрэл, 641 ширхэг 50 вт прожуктор, 163 ширхэг пускатель, 380 ширхэг 50 вт лед трансформатор, 68 ширхэг 70 вт лед трансформатор, 252 ширхэг гал хамгаалагч, 210 ширхэг цахилгааны самбарын хайрцгийг засварлаж, 95 ширхэг гэрэлтүүлгийн шонг сольж, шинэчилсэн.

Иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх ажлын хүрээнд Ажилчны гудамж, Үйлдвэрийн гудамж дагуу таггүй 137, Наадамчдын зам дагуу 171 гэрэлтүүлгийн шонг тагжуулж, ил гарсан 17461 метр кабелийг цэгцэлж булж, орчны аюулгүй байдлыг хангасан.

Дунд голын гудамж дагуу 40 гэрэлтүүлгийн шонг шилжүүлж, явган хүний замын зорчих хэсгийг чөлөөлсөн. Гэрэлтүүлгийн асалт 99.1 хувьтай байна.

Зураг. Хан-Уул дүүрэг, гэрэлтүүлгийн засвар, үйлчилгээний ажлын явц



Дунд голын гудамж дагуу явган хүний зам голлосон 20 ширхэг гэрэлтүүлгийн шонг шилжүүлж, явган хүний зорчих хөдөлгөөнийг чөлөөлөх, төвийн хороодод хуучирсан 48 ширхэг гэрэлтүүлгийг будаж, өнгө үзэмжийг сэргээх арга хэмжээг тус тус авч хэрэгжүүлсэн.

Дүүргийн төсөв, дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн 1.59 тэрбум төгрөгийн хөрөнгөөр 2, 5, 8, 9, 10, 11, 12, 13, 14, 16, 21, 23, 24 дүгээр хороодын нийтийн эзэмшлийн гудамж талбайд 526 ширхэг гэрэлтүүлэг шинээр суурилуулах 3 төсөл арга хэмжээнээс 1 төсөл арга хэмжээ ажил гүйцэтгэх, 2 төсөл арга хэмжээ худалдан авах ажиллагааны шатанд хэрэгжиж байна. Үүнд:

1. Дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн 2023 оны 1.0 тэрбум хөрөнгөөр 2, 5, 8, 9, 10, 11, 12, 13, 14, 16, 21, 23, 24 дүгээр хороодын нийтийн эзэмшлийн гудамж талбайд 360


ширхэг гэрэлтүүлэг шинээр суурилуулах ажлын тендер 2023 онд 4 удаа зарлаж амжилтгүй болсон. Дахин тендер зарлах шатанд хэрэгжиж байна.

2. Нийтийн эзэмшлийн гудамж талбайн гэрэлтүүлгийн ажил (13 дугаар хороо) гүйцэтгэгч шалгаруулах шатанд хэрэгжиж байна.

3. Наадамчдын авто замаас Нүхт чиглэлийн авто замын гэрэлтүүлгийн ажил (23 дугаар хороо)-ын гүйцэтгэгчээр "Ингүүмэл эрчим" ХХК шалгарч, гэрээ байгуулж, ажил эхэлсэн.

Дүүргийн төсвийн хөрөнгөөр хэрэгжсэн тохижилт бүтээн байгуулалтын ажлын хүрээнд 4, 5, 7, 8, 20 дугаар хороонд 138 ширхэг гэрэлтүүлэг шинээр суурилуулсан.

Зураг. Хан-Уул дүүрэг, шинээр гэрэлтүүлэг суурилуулах ажлын явц



6. Камержуулалтын чиглэлээр:

Нийслэлийн орон нутгийн хөгжлийн сан, дүүргийн төсөв, дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2023 онд нийтийн эзэмшлийн гудамж талбайг камержуулах, орчны аюулгүй байдлыг хангах чиглэлээр хэрэгжих 7 төсөл арга хэмжээний хүрээнд нийт 380 ширхэг камер суурилуулахаар төлөвлөсөн. Дүүргийн төсвийн 75.0 сая төгрөгийн хөрөнгөөр хэрэгжиж буй "Камерын хяналтын нэгдсэн төв рүү шилэн кабель татах, дотор заслын ажил"-ын шилэн кабелийн ажил бүрэн дуусаж, барилгын дотор заслын ажил хийгдэж байна. Тус төв ашиглалтад орсоноор камерын угсралтын ажил дууссан төсөл арга хэмжээнүүд ашиглалтад орохоор хүлээгдэж байна.

Зураг. Шинээр камер суурилуулах ажил




7. Хог хаягдлын асуудлаар хандсан гомдлыг бүүрүүлэх чиглэлээр:

Дүүргийн Засаг даргын 2022 оны 12 сарын 30-ны өдрийн А/647 дугаар Захирамжаар хог тээврийн гэрээ байгуулахыг хороодын Засаг дарга нарт шилжүүлж, "Хог хаягдал, цуглуулах, тээвэрлэх гэрээ"-ний загварыг шинэчлэн боловсруулсан.

Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 01 дүгээр сарын 20-ны өдрийн №2 дугаар шуурхай зөвлөгөөнөөс өгсөн үүрэг даалгаврын дагуу “Хог хаягдал, цуглуулах, тээвэрлэх гэрээ”-ний хавсралтаар аж ахуй нэгж, байгууллагын тохижилт, цэвэрлэгээг хариуцах орчны 50 метр хүртэлх нийтийн эдэлбэр газрын зураглал хавсаргаж эхэлсэн. Тус ажлын хүрээнд орчны 50 метрийн зураглалыг дүүргийн хэмжээнд Arc GIS програмд нэгтгэн бүртгэж, мэдээллийн сан үүсгэх ажлыг тогтмол хэрэгжүүлж байна.

Хог хаягдал цуглуулах, тээвэрлэх гэрээний загварыг шинэчлэн дүүргийн нийт **537 аж ахуйн нэгж байгууллагатай** шинээр гэрээ байгуулсан. Гэрээний хэрэгжилтэд хяналт тавих зорилгоор дүүргийн Засаг даргын Тамгын газар, Татварын хэлтэс, хог тээврийн байгууллагууд, хороодын дундын мэдээллийн санг /Google sheet/ үүсгэн 7 хоног бүр мэдээллийг шинэчилж байгаа бөгөөд **537 байгууллагын мэдээлэл** бүртгэгдсэн.

Дүүргийн хэмжээнд хүнс, худалдаа үйлчилгээ явуулж байгаа **898 аж ахуйн нэгж**, байгууллагын тохижилт, цэвэрлэгээг хариуцах орчны 50 метр хүртэлх нийтийн эдэлбэр газрын зураглалыг гэрээний хавсралтаар баталгаажуулж, **Газар зүйн мэдээллийн системд (ArcGIS) бүртгэсэн.**



Аж ахуй нэгж, байгууллагын тохижилт, цэвэрлэгээг хариуцах орчны 50 метр хүртэлх нийтийн эдэлбэр газрын зураглалын загвар


Хог хаягдал цуглуулах, тээвэрлэх гэрээний хавсралт:		
Аж ахуй нэгж, байгууллага	Сууц өмчлөгчдийн холбоо	Иргэн
1. Албан хүсэлт	1. Албан хүсэлт	1. Өргөдөл
2. Байгууллагын гэрчилгээний хуулбар	2. СӨХ-ны гэрчилгээний хуулбар	2. Иргэний үнэмлэхний хуулбар
3. Хариуцах орчны 50 метрийн зураглал /хорооны Засаг даргын баталгаажуулсан/	3. Хариуцах орчны 50 метрийн зураглал /хорооны Засаг даргын баталгаажуулсан/	3. Хариуцах орчны 50 метрийн зураглал /хорооны Засаг даргын баталгаажуулсан/
✓ 2023.05.01-НИЙ ӨДРИЙН БАЙДЛААР ДҮҮРГИЙН ХЭМЖЭЭНД 498 ААНБ-Н ЗУРАГЛАЛЫГ ШИНЭЧЛЭН ГАРГАСАН БАЙНА.		



- “Хог хаягдал, цуглуулах, тээвэрлэх гэрээ”-ний 01 ноо, дугаарыг бичнэ.
- Хорооноос хариуцах орчны 50 метрийн хил ааныг тогтоох, дүүргээс гаргасан загварт тухайн мэдээллийг компьютерээр оруулна
 - Хороон дарга зураглалыг гарын үсэг тамгаар баталгаажуулан гэрээнд хавсаргана
- ✓ Хороо тус бүр КМЗ форматаар ААНБ-н зураглалыг тэмдэглэн мэдээллийн сан үүсгэсэн.

Аяны хүрээнд өөрийн эзэмшил газраас гадна нийтийн эзэмшлийн гудамж, талбайг тохижуулахаар 1 иргэн, 3 аж ахуйн нэгжээс ирүүлсэн хүсэлтийн дагуу газар дээр нь ажиллаж, зөвлөмж мэдээлэл хүргүүлсэн. Үүнд: Хан-Уул дүүрэг, 21 дүгээр хороо, Шидэт гүүр ХХК, иргэн Энхбат, 3 дугаар хороо, Ворлд вайн трейдинг ХХК, АНУН төв

Зураг. Хан-Уул дүүрэг, орчны тохижилт хийх аж ахуйн нэгж, байгууллагууд



Дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй зочид буудал, дэн буудал, амралтын газар, жуулчны бааз, хоол үйлдвэрлэлийн газруудад шинэчлэгдэн батлагдсан стандартуудыг танилцуулах, хүнсний аюулгүй байдлыг хангуулах чиглэлээр 4 удаагийн сургалт, уулзалтыг зохион байгуулж, давхардсан тоогоор 1239 иргэн аж ахуйн нэгжийг хамруулсан.

/Сургалтын явц, зохион байгуулалт/



“Хоггүй Хан-Уул” аяныг эрчимжүүлэх ажлын хүрээнд “Аянд нэгдэх тухай” 08/508 дугаар албан бичгийг нийт 600 гаруй аж ахуйн нэгж, байгууллагуудад хүргүүлж, дүүрэг үйл ажиллагаа явуулж буй ахуйн нэгжийг хамруулсан их цэвэрлэгээг 2023 оны 04 дүгээр сарын 08, 09-ний өдрүүдэд зохион байгуулсан. Аянд нийт 200 гаруй аж ахуйн нэгж оролцож 15,000 м² орчим талбайг цэвэрлэн, 4 автобусны буудалд хөөстэй угаалга хийж орчны өнгө үзэмжийг сайжруулсан.

Хан-Уул дүүрэг, аж ахуйн нэгж, байгууллагуудын их цэвэрлэгээний явц



Дүүргийн Засаг даргын 2023 оны А/54 дүгээр захирамжаар батлагдсан "Хоггүй Хан-Уул 2023" аяны хүрээнд дүүргийн хэмжээнд 7 удаагийн бүх нийтийн их цэвэрлэгээг зохион байгуулж, Засаг даргын Тамгын газар, дэргэдэх хэлтэс, албад болон дүүргийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг нийт 7947 аж ахуй нэгж байгууллага, 308 сууц өмчлөгчдийн холбоодын 12,450 хүн оролцож, 715,311 м.кв талбайгаас 368,7 тонн хог хаягдлыг цэвэрлэсэн байна.

Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах талаар мэдээлэл өгөх, дахивар хог хаягдал авах сургалт, дахивар авах өдөрлөгийг 2 удаа зохион байгуулж, нийт 500 гаруй иргэн, 20 гаруй сууц өмчлөгчдийн холбоод, аж ахуй нэгж, байгууллага оролцож, дахин ашиглах боломжтой 13 төрлийн нийт 4974 кг хог хаягдлыг тушааж, дахин боловсруулах үйлдвэрүүдэд хүргэсэн.

Зураг. Дахивар авах өдөрлөг



Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанаас жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг “Өгөөмөр өдөр” арга хэмжээг батлагдсан удирдамжийн дагуу 2023 оны 06 дугаар сарын 10-ны өдрөөс 06 дугаар сарын 20-ны өдрийг хүртэл дүүргийн хэмжээнд зохион байгуулж, нийт 50 аж ахуй нэгж байгууллагын 441 иргэн оролцож хүнс, ном, дэвтэр, тоглоом, гутал хувцас, цахилгаан бараа, спортын хэрэгсэл гэх мэт нийт 30 гаруй нэр төрлийн 907 ширхэг (5 тонн) эд зүйлс цуглаж дахин ашиглах боломжтой болж, хог хаягдлыг эх үүсвэр дээр нь бууруулсан.

Зураг . Хороодоор дамжуулан “Өгөөмөр өдөр” арга хэмжээнд оролцон эд зүйл хүлээлгэн өгсөн иргэн, байгууллагууд



Хандиваар цугларсан эд зүйлийг хүлээн авах, солилцох “Өгөөмөр өдөр” нэгдсэн өдөрлөгийг Ажилчны алдар талбайд 2023 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн 11.00-16.00 цагийн хооронд зохион байгуулсан.

Зураг . “Өгөөмөр өдөр” нэгдсэн арга хэмжээ



8. Хөрс, орчны бохирдлыг бууруулах бүх нийтийн их цэвэрлэгээ, ариутгал, халдваргүйжүүлэлтийн асуудлаар хандсан гомдлыг бууруулах чиглэлээр:

Дүүргийн Засаг даргын 2023 оны А/54 дүгээр захирамжийн дагуу дүүргийн хэмжээнд 12 удаагийн бүх нийтийн их цэвэрлэгээг зохион байгуулж, Засаг даргын Тамгын газар, дэргэдэх хэлтэс, албад болон дүүргийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг нийт 8125 аж ахуй нэгж байгууллага, 309 сууц өмчлөгчдийн холбоодын 15,600 хүн оролцож, 215,311 м.кв талбайгаас 451,8 тонн хог хаягдлыг цэвэрлэсэн.

“Хаврын их цэвэрлэгээ” сарын аяны хүрээнд 115 автобусны буудал, 2,850 урт метр хайс хашлага, 205 авто замын тэмдэг тэмдэглэгээ, 26 хөшөө дурсгал, 455 спорт болон тоглоомын талбай, 226 хогийн сав, 210 сандлыг тус тус угааж цэвэрлэсэн.

Зураг. “Хоггүй Хан-Уул 2023” аяны хүрээнд зохион байгуулсан бүх нийтийн их цэвэрлэгээний ажлын явц



Дүүргийн Засаг даргын 2023 оны А/286 дугаар захирамжийн дагуу 8, 10, 12, 13, 14, 21 дүгээр хороодын нутаг дэвсгэрт үхсэн мал амьтны сэг зэм, өтөг бууцыг цэвэрлэж,

ариутгаж халдваргүйжүүлсэн. Дүүргийн 5, 22 дугаар хорооны нутаг дэвсгэрт бохир хальсан болон хогийн цэгийн 15,000 м.кв талбайг ариутгаж, халдваргүйжүүлсэн.

Зураг. Дүүргийн 5-р хороо, нийтийн байрны цэвэрлэгээ, ариутгал халдваргүйжүүлэлтийн ажлын явц



Зураг. Үхсэн мал, амьтны сэг зэм, хур хог хаягдлыг ачиж, ариутгасан байдал



Дүүргийн Засаг даргын 2023 оны А/196 дугаар захирамжийн хүрээнд гэр хорооллын 12099 нүхэн жорлон, 5732 бохирын цооногийг ариутгаж, халдваргүйжүүлсэн. Нийслэлд орсон их хэмжээний борооны дараа үерийн уснаас халдварт өвчин тархах эрсдэлээс урьдчилэн сэргийлэх ажлын хүрээнд үерийн усанд автсан нийтийн эзэмшлийн гудамж, талбай, орон сууц, сургууль, цэцэрлэгийн барилгуудын нийт 300,700 м.кв талбайг ариутгаж халдваргүйжүүлсэн.

Зураг. Нүхэн жорлон, бохирын цооногийг ариутгаж, халдваргүйжүүлсэн байдал



9. Нийтийн эзэмшлийн зам талбайн цэвэрлэгээ, үйлчилгээний гомдлын хүрээнд:

Дүүргийн авто зам, явган замын цэвэрлэгээ, үйлчилгээг шинээр хариуцаж буй 9 байгууллага болох Хот тохижилтын газар ОНӨААТҮГ, "Чингэлтэй ТҮК" ХХК "Охь мандал"

ХХК, “Эко эрин тохижилт” ХХК, “Экспресс зам” ХХК, “ТЖН Форестри” ХХК, “Гранд зевс” ХХК-ийн хариуцсан 18 байршлын 2,332,290 м.кв талбай бүхий авто зам, явган зам, “Тохижилт үйлчилгээний төв” ОНӨААТҮГ-ын хариуцсан 126 байршлын 1,043,793 м.кв талбай бүхий туслах замын цэвэрлэгээ үйлчилгээнд тогтмол хяналт тавин ажиллаж байна. Тус ажлын хүрээнд халтиргаа гулгааг арилгах чиглэлээр 4 удаагийн бүх нийтийн их цэвэрлэгээг зохион байгуулж, нийт 26.5 тонн цас мөсийг цэвэрлэн, халтиргаа гулгаанаас сэргийлэн ажилласан.

Зураг . Авто зам, явган замын цас, мөс цэвэрлэгээний ажлын явц



Зураг. Авто зам, явган замын хог цэвэрлэгээний ажлын явц



2022-2023 оны өвлийн улиралд замын цас мөсийг цэвэрлэх, халтиргаа гулгааг арилгах зорилгоор 2023 онд 510.5 тн давс, 43 тн бодис цацсан. Засаг даргын 2023 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн зөвлөлийн хурлаас өгсөн үүрэг даалгаврын дагуу дүүргийн 25 хороодын нутаг дэвсгэрт халтиргаа гулгааг ихээр үүсдэг, өгсүүр байршлуудад 68 ширхэг давс, бодисны нөөцийн сав байршуулж, давс, бодисоор дүүргэж, яаралтай үед ашиглах нөхцөлийг бүрдүүлж ажилласан.

Зураг. Давс, бодисны нөөцийн сав байршуулсан байдал



10. Эрүүл мэндийн салбарын үйл ажиллагаатай холбоотой.

Эрүүл мэндийн төв дээр хэвтэн эмчлүүлэхээр дараалал үүссэнтэй холбоотой гомдлыг бууруулахаар Нийслэлийн эрүүл мэндийн газрын даргын 124 дүгээр албан бичгээр Туул тосгоны эрүүл мэндийн төвд насанд хүрэгчдийн хэвтэн эмчлүүлэх 20 ортой тасаг нээн ажиллууж байна.

Эрүүл мэндийн төвийн даргын 2023 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн “Эмнэлгийн тусламж үйлчилгээг зохицуулах тухай” А/78 дугаар тушаалаар бага насны хүүхдийн амьсгалын замын өвчлөл, томуу, томуу төст өвчний идэвхжил, дэгдэлт нэмэгдэж байгаатай холбогдуулан Эрүүл мэндийн төвийн хүүхдийн амбулаторыг ажлын өдрүүдэд 17:00-21:00 цаг, бямба гарагт 12.00-18.00 цаг, Өрхийн эрүүл мэндийн төвүүдийг ажлын өдрүүдэд 17:00-20:00 цаг, ням гарагт 10:00-15:00 цаг хүртэл тус тус ажиллаж байна.

2023 онд Эрүүл мэндийн төвийн гемодиализ эмчилгээтэй холбоотой Гемодиализ эмчилгээг өргөтгөн зохион байгуулж шинээр аппарат тоног төхөөрөмжийн сувилагч нарын орон тоог 1-ээр нэмэгдүүлж хүчин чадлыг 25% нэмэгдүүлэн ажиллаж үйлчлүүлэгчдийн хүлээгдлийг бууруулан Гемодиализ эмчилгээний хэсгийн засвар өрөө тасалгааг нэмэгдүүлэн ажиллаж байна. Иргэнээс ирэх өргөдөл, гомдлыг бууруулах зорилгоор орон тоог нэмэгдүүлэн ажилласан. Үүнд:


- Цахим бүртгэлийн ажилтанг - 1
- Дотрын эмчийг -1
- Уушиг судлалын мэргэжлийн эмч -1
- Эмэгтэйчүүдийн бага эмч-1.

11. Газар чөлөөлөх тухай.

Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/242 дугаар захирамжаар батлагдсан иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах зорилтын хүрээнд хууль, норм, дүрэм, стандартын хэрэгжилтийг хангуулах нэгдсэн арга хэмжээний удирдамж, төлөвлөгөөг хэрэгжүүлэх, хяналт тавих, тайлагнах ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна.

Нийтийн эзэмшлийн зам талбай, сургууль, цэцэрлэгийн орчимд зөвшөөрөлгүй байршуулсан **61 түргэн үйлчилгээний цэгийг** нүүлгэн шилжүүлж, явган хүний зам талбайг чөлөөлөх арга хэмжээ авсан. Үүнд:

- Зайсан Туул гол дагуу 15 түргэн хоолны цэг
- Наадамчдын зам дагуу 14
- Чингисийн өргөн чөлөө дагуу Ажилчны талбайн 11
- Яармагийн 118 дугаар сургуулийн баруун талын 4, Яармагийн 3-р буудал, эмнэлгийн автобусны буудлын 4 ТҮЦ-ийг тус тус нүүлгэн шилжүүлсэн.
- 10-р хороо, Нисэхийн зам дагуу 3 түргэн үйлчилгээний цэг





Дүүргийн төсвийн 298.0 сая төгрөгийн хөрөнгөөр газар зохион байгуулалтын 2023 оны төлөвлөгөөнд дүүргийн хэмжээнд зөрчилтэй 5284 урт метр хашаа, хайс, хаалт болон 3, 10, 19 дүгээр хороонд зөвшөөрөлгүй баригдсан 155 гараашийг чөлөөлөхөөр төлөвлөгдсөнөөс 2023 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн байдлаар 120 гараашийг буулгаж газар чөлөөлсөн. Дүүргийн 3 дугаар хорооны Энгельсийн гудамжинд байрлах 4 гарааш төрийн өмчид бүртгэлтэй, 19 дүгээр хорооны 85 дугаар байрны урд байрлах 15 гараашийн үл хөдлөхийн гэрчилгээтэй, шүүхийн маргаан эцэслэн шийдвэрлэгдээгүй тул газар чөлөөлөх ажил хэрэгжээгүй.

Хан-Уул дүүрэгт гарааш чөлөөлж, зөрчил арилгасан газарт хийгдэх тохижилтын ажлын явц


2023 онд гарааш чөлөөлж, зөрчил арилгасан газарт хийгдэж буй тохижилтын ажлын мэдээ							
Д/д	Дүүрэг, Байршлын тоо	Батлагдсан Архитектур төлөвлөлтийн даалгавар	Тохижилт хийгдсэн болон төлөвлөгдсөн талбайн хэмжээ, гараашийн тоо		Төрөл	Байршил, Хаяг	Төсөв хувь
	1	2	4		6	7	
1	Хан-Уул 3, 10, 19 дүгээр хорооны 9 байршлын 155 гарааш буухаар төлөвлөгдсөнөөс 120 гарааш буулгаж газар чөлөөлсөн.	Хот байгуулалт, хөгжлийн газрын 2023 оны 04 сарын 20-ны өдөр МЗХ2023/10-026	22 гарааш 1200 м.кв	Төлөвлөгдсөн	Өрхийн эрүүл мэндийн төвийн барилга	10 дугаар хороо, 49 дүгээр цэцэрлэгийн хойд талд	ДТХО 500.0 сая төгрөг
			17 гарааш 450 м.кв		10 дугаар хорооны байрны ард	34, 35 дугаар байрны дахин төлөвлөлтийн барилгажилтын талбайд орсон	
		Хот байгуулалт хөгжлийн газрын 2019 оны ГБМЗХ2019/02-039 дугаартай тохижилтын даалгавар.Хот байгуулалт хөгжлийн газрын 2023 оны ХТХ2023/00-072,	24 гарааш 880 м.кв		10 дугаар хороо 64-р байрны хойд талд	Авто зогсоол	
		ХТХ2023/00-072,	11 гарааш 300 м.кв		19 дүгээр хороо Шинэ зуун билэг сургуулийн баруун талд	Авто зогсоол	
		ХТХ2023/00-073 дугаартай тохижилтын даалгавар.	16 гарааш 500 м.кв		115-р сургуулийн зүүн урагш, 60А байрны зүүн талд	Авто зогсоол	

			21 гарааш 350 м.кв		115-р сургуулийн зүүн урд, Дэд станцын урд, 54Д байрны зүүн	Авто зогсоол		
			4 гарааш 400 м.кв /2022 онд буусан/		2 дугаар хороо 8А байрны байрны хойд талд	Авто зогсоол		
			4 гарааш 150 м.кв /2022 онд буусан/		3 дугаар хороо 1А байрны байрны урд талд	Авто зогсоол		
			Архитектур төлөвлөлтийн даалгаваргүй	3 гарааш		3 дугаар хороо Үйлдвэрийн гудамж	Хувийн хэвшлээр тохижуулахаар ажиллаж байна.	
				38 гарааш 1200 м.кв	-	Этүгэн сургуулиас урагш 65, 70А, 85-р байрны урд	Туулын хурдны замын трасс давхацсан	
				2 гарааш	-	58А байрны урд	2 чингэлэг нүүлгэсэн.	
		ШҮҮХИЙН МАРГААНТАЙ ГАЗАР ЧӨЛӨӨЛӨӨГҮЙ БАЙРШЛУУД						
2	ХУД, 3-р хороо		4 гарааш 100 м.кв		3 дугаар хороо Энгельсийн гудамж	Төрийн өмчид бүртгэлтэй		
	ХУД, 19-р хороо		15 гарааш		19 дүгээр хороо Этүгэн сургуулиас урагш 85-р байрны урд	Үл хөдлөхийн гэрчилгээтэй, шүүхийн маргаан эцэслэн шийдвэрлэгдээгүй.		

Хан-Уул дүүрэг, 10 дугаар хороо, гарааш буулгаж, газар чөлөөлсөн талбай – Өрхийн эрүүл мэндийн төвийн барилга баригдахаар төлөвлөгдсөн.




Зураг. Хан-Уул дүүргийн 2, 3, 10, 19 дүгээр хороонд газар чөлөөлсөн 6 байршилд дүүргийн төсвийн 500.0 сая төгрөгийн хөрөнгөөр тохижилт хийх ажлын гүйцэтгэгч шалгаруулах тендер үнэлгээ хийгдэж байна.



Чингисийн өргөн чөлөө дагуу 1903 урт метр хашааг буулгах, стандартын шаардлага хангуулах арга хэмжээ авч ажилласан.



Хан-Уул дүүргийн 17 дугаар хороонд Эрдэнийн төгөл хотхон орчимд 20 м.кв тоосгон ханыг буулгаж, явган зорчигчийн орц гарц чөлөөлөх арга хэмжээ авсан. Тус байршилд дүүргийн төсвөөр явган зам хийхээр зураг төсөл боловсруулж байна.



Хан-Уул дүүргийн 14 дүгээр хорооны Ногоочдын хэсэгт нэгж талбараасаа илүү хашаалсан, голын урсац хаасан байршлыг 54 м.кв ханыг буулгаж, газар чөлөөлсөн.



ГУРАВ.ИРГЭДЭЭС ИРҮҮЛСЭН САНАЛ

Д/д	Өргөдлийн дугаар	Товч агуулга	Хариу	Шийдвэрлэсэн байдал
1	G230102015	ХУД-ийн 19 дүгээр хороо, Эвсэг кашмерийн талын ногоон байгууламжийн бургас модыг 12 дугаар сарын 24- өөс хөрөөдөөд хаячихлаа. Маш олон бургасыг хөрөөдөж, ногоон байгууламжийг сүйтгэлээ. Ингэж ногоон байгууламжийг сүйтгээд баймааргүй байна. Энэ асуудлыг холбогдох газарт нь уламжилж, хариу өгнө үү.	Иргэний гаргасан саналын дагуу 2023 оны 01 дүгээр сарын 03-ны өдөр 19 дүгээр хорооны Засаг дарга, зохион байгуулагч нар Эвсэг кашмер орчимд газар дээр нь хяналт тавьж ажиллалаа. Тус байршил дээр мод, бут тайрсан үйл ажиллагаа явуулаагүй байна. Иргэнд бүртгэгдсэн дугаараар мэдээлэл, тайлбар хүргүүлэх гэсэн боловч 89881138 дугаар нь ашиглалтад байхгүй байна.	Иргэний талд шийдвэрлэсэн өргөдөл
2	G230301120	ХУД-ийн 18-р хорооны Кинг товер хотхон болон Хүннү 22 хотхоны дундуур явдаг зам Маршалл таун хотхоноос Олимпын гүүр лүү эргэх замын гэрэл олон сар огт ассангүй. Сургуулийн насны хүүхдүүд нийтийн тээвэр хүлээж зогсох болон тэр зам орчмоор зорчдог учраас их харанхуй аюултай байгаа юм. Тиймээс эдгээр гэрлийг асаах өгөхийг хүсэж байна. Холбогдох газарт нь уламжилж өгнө үү.	Тухайн хэсгийн гэрэлтүүлгийн асалтыг Улаанбаатар хотын Захирагчийн алба хариуцдаг тул Улаанбаатар хотын Захирагчийн албаны гэрэлтүүлэг хариуцсан мэргэжилтэнд хандана уу.	Боломжгүй тухай хариу өгсөн өргөдөл
3	O230322013	19-р хорооны 56в, 56г, 56д байруудын иргэд 1 бүрийг нь 15 сая төгрөгөөр худалдаж авсан автомашины дулаан зогсоолыг буулгаж газар чөлөөлөх тухай "Мэдэгдэх хуудас" ирүүлсний дагуу тухайн автозогсоолын эзэдийн өөрсдийн хөрөнгөөр зогсоолыг буулгалгүй гадна талын тохижилтын ажлыг хийх санал хүргүүл байна.	Дүүргийн Засаг даргын орлогчийн 2023 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн 11/121 дүгээр албан бичгээр хариу өгсөн.	Боломжгүй тухай хариу өгсөн өргөдөл
4	J230322006	Хан-Уул дүүргийн Том Үо сургуулиас Арцатын ам руу явах зам дагуу гэрэлтүүлэг огт байхгүй.Гэрэлтүүлэг хийж өгнө үү.	2023 онд дүүргийн төсвийн хөрөнгөөр хийгдэхээр төлөвлөгдсөн тул өргөдлийг хаав.	Иргэний талд шийдвэрлэсэн өргөдөл
5	G230330157	ХУД-ийн 2-р хорооны энэ нарийхан туслах замын хажуугаар явган хүний зам байхгүй. Одоо битүү барилга баригдаад хэзээ дээрээс юм унах бол мөн машинууд нь мөргөчих гээд үнэхээр маш том эрсдэл, хүндрэлтэй оршин суугчид, иргэд амьдарч байна. Сургуулийн насны хүүхдүүд өдөр болгон, орой болгон ийм эрсдэлтэй газраар явж байна. Яаралтай явган хүний аюулгүй өргөн зам тавьж асуудлыг яаралтай шийдвэрлэж өгнө үү Та бүхэн өөрсдөө ажилдаа энүүгээр өглөө өдөр орой болгон явж үзээч Яг хэдэн сарын хэдэнд ажил эхлэх талаар тодорхой хариу өгнө үү Одоогоор ямар ч ажил хийгдээгүй хавар болоод улам дуу чимээ ихтэй шороо боссон аюул улам нэмэгдэж байна	Дүүргийн төсвийн хөрөнгөөр хэрэгжих "Явган зам, талбайн засвар, шинэчлэлт /1, 2, 3-р хороо/" ажлын хүрээнд тус байршилд явган зам тавихаар төлөвлөгдсөн бөгөөд 2023 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар худалдан авах ажиллагааны гүйцэтгэгч сонгон шалгаруулах шатанд хэрэгжиж байна. Ажлын явцын талаар иргэнд мэдээлэл өгсөн. Холбоос: https://www.tender.gov.mn/mn/invitation/detail/1679449749454	Иргэний талд шийдвэрлэсэн өргөдөл

6	G230331185	ХУД-ийн яармагт маш их бүтээн байгуулалт явагдаж байна. Үүнийгээ дагаад маш хүн ам суурьшиж байна. Яармаг хавьд улсын ганцхан улсын сургуулиуд байрлаж байна. Хувийн сургуулиуд байдаг боловч төлбөр нь маш үнэтэй байдаг тул айл өрх болгон бүх хүүхдүүдээ явуулж чадахгүй шүү дээ. Тиймээс Яармагт улсын сургууль болон цэцэрлэгүүдийг хэд хэдийг барьж өгөх хэрэгтэй байна. Миний саналыг холбогдох байгууллагад уламжилж өгнө үү.	Иргэн Халиунтай утсаар холбогдож яармаг орчимд шинээр барихаар төлөвлөсөн сургууль цэцэрлэгийн талаар мэдээлэл өгсөн.	Иргэний талд шийдвэрлэс эн өргөдөл
7	G230404063	Хорооны хэсгийн ахлагч нарт тавьдаг шалгуурыг өндөр болгомоор байна. Бичиг үсэг мэдэхгүй, харилцааны соёлгүй, боловсролгүй хүмүүс маш их байна. Тэтгэвэртээ гарсан хэрнээ ажиллаж байгаа хүмүүс ч байна. Энэ асуудлаар санал өгсөн байгаа боловч хуулийн зүйл заалт оруулан тайлбар оруулсан байна. Хэсгийн ахлагч нараар мэдлэг боловсролтой, иргэддээ сайн мэдээлэл өгчихдөг зэрэг өндөр шалгуур тавьж шалгаруулж авна уу гэсэн саналтай. Энэ асуудлыг холбогдох газар нь уламжилж, иргэнд хариу өгнө үү. Утас: 98542598	Иргэнтэй холбогдож холбогдох тайлбарыг хүргүүлж, гомдлыг барагдуулсан.	Иргэний талд шийдвэрлэс эн өргөдөл
8	G230417002	ХУД-ийн 19-р хороо 42А байрны зүүн талд зам засварын ажил хийгдэж байна. Кабелын шугамыг хамгаалж байна гээд явган хүний замыг хуулж аваад муруй саруйгаар өрлөг хийчихсэн бөгөөд 50-ын шугамаар оруулчихсан. Явган хүний замыг хуулаад авчихсан хөрсөн дээр нь цахилгааны утас ил гарчихсан байна, одоо бороо цас орж байна цахилгааны утас байгаад тогны хэлбэлзэл гараад иргэд хохирвол яах вэ. Зураг төслийг ямар албан тушаалтан гаргаж баталсан бэ. Энэ хуулсан явган хүний замын тоосгыг буцааж тавих хэрэгтэй байна. Энэ асуудлыг холбогдох газарт нь уламжилж, арга хэмжээ авч хариу өгнө үү.	Тухайн иргэний гомдлын дагуу Нийслэлийн замын хөгжлийн газрын захиалагчийн хяналтын инженер болон шилэн кабелийн хариуцагч байгууллагатай хамтарсан үзлэг шалгалтыг гүйцэтгэгч байгууллага болох Хан-Уул зам засвар, арчлалт ОНӨААТҮГ хийлгэсэн. Ажлын зураг төсвөөс зөрсөн, ноцтой гарсан зөрчилгүй байсан тул иргэнд тайлбар хүргүүлэхээр хариуцаж буй инженертэй холбож өгч ажиллалаа. Мэдээллийг иргэний 94001460 дугаарын утсанд бичиж хүргэсэн.	Иргэний талд шийдвэрлэс эн өргөдөл
9	C230503001	ХУД-ийн 15-р хорооны Рапит хорооллын Цэнгэлдэх сөх нь лифтээ зогсоосонд гомдолтой байна.	Тус гомдлын дагуу Цэнгэлдэх өргөө сууц өмчлөгчдийн холбоонд шаардлага хүргүүлж лифт хэвийн ажиллагаанд орсон иргэнтэй холбогдон мэдээлэн хүргүүлэн ажилласан.	Иргэний талд шийдвэрлэс эн өргөдөл

10	G230504048	ХУД-ийн 15-р хороо Махамат Ганди гудамж-218, 130-р сургууль цэцэрлэг рүү ордог замыг хэзээ засах вэ? Шороон замтай, явган хүний замгүй учраас хүүхэд дайруулчих шахаад машинд шүргүүлээд байна. Энэ асуудлыг холбогдох газарт нь уламжилж, арга хэмжээ авч өгнө үү.	Тус байршилд иргэдээс авто зам, явган зам тавиулах хүсэлтийг ихээр ирүүлдэг. Махатма Гандигийн гудамжнаас Нархан хотхоны баруун талаар Ерөнхий боловсролын 130 дугаар сургууль, 218 дугаар цэцэрлэгийн зүүн хойд тал хүртэлх авто замын аюулгүй байдлыг хангуулах арга хэмжээ авах тухай Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын 2023 оны 04 дүгээр сарын 21-ний 03/659 дугаартай албан бичгээр Хотын стандарт, хяналтын газарт уламжилсан.	Боломжгүй тухай хариу өгсөн өргөдөл
11	G230505010	Хан-Уул дүүргийн Их тэнгэрийн амны баруун талын Туул гол дагуух хоолны автомашинууд ихээр зогсож байна. Үүнээс болж Туул голын эргээр хог хаягдал ихээр үүсэж байна. Холбогдох байгууллага нь тус асуудалд хяналт тавьж өгнө үү.	Тус гомдлын дагуу худалдаа эхлэгчдэд шаардлага тавьж, дүүргийн газар зохион байгуулалтын албатай хамтран газар чөлөөлөх, нүүлгэн шилжүүлэх тухай Засаг даргын А/202 захирамжийг хүргүүлсэн.	Иргэний талд шийдвэрлэс эн өргөдөл
12	G230516039	ХУД-ийн 20 дугаар хороо, Шаргын гудамжны босоо чиглэлд явган хүний зам байхгүй байна. Хүүхдээ сургуулиас нь аваад алхаад харих гэхээр ямар ч явган хүний зам байхгүй, замын хөдөлгөөн дундуур явах ёстой юм уу, явган хүн явах нөхцөл байхгүй байна. Энэ асуудлыг холбогдох газарт нь уламжилж, явган хүний замтай болгож өгнө үү.	Тус байршилд дүүргийн Зам засвар арчлалт ОНАААТҮГ засварлаж ашиглалтад оруулж дууссан. Иргэний өргөдлийг шийдвэрлэсэн талаар 80561111 утсаар холбогдож мэдэгдсэн.	Иргэний талд шийдвэрлэс эн өргөдөл
13	G230522138	ХУД-ийн Яармагийн автобусны буудлууд дээр явган хүний зам дээр хаагаад түцнүүд байрлуулснаас болоод явган хүн явах боломжгүй болчихоод байна. Энэ асуудлыг холбогдох газарт нь уламжилж, түцийг нүүлгэж өгнө үү.	Таны ирүүлсэн гомдолтой танилцаж, дараах хариуг хүргүүлж байна. Дүүргийн нутаг дэвсгэрт иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг зөрчиж нийтийн эзэмшлийн зам талбай, явган хүний зам хааж, зөвшөөрөлгүй байршуулсан түргэн үйлчилгээний цэгүүдийг нүүлгэн шилжүүлж, зөрчлийг арилгах чиглэлээр дүүргийн Засаг даргын 2023 оны "Газрын зөрчил арилгаж, нүүлгэн шилжүүлэх арга хэмжээ авах тухай" А/202 дугаар захирамж батлагдсан. Захирамжийн хэрэгжилтийг хангах хүрээнд Газар зохион байгуулалтын албатай хамтран наадамчдын зам, зайсангийн зам, туул гол дагуу зөвшөөрөлгүй үйл ажиллагаа явуулж буй түргэн үйлчилгээний цэг, явуулын үйлчилгээтэй түргэн хоолны үйлчилгээ эрхлэгчдэд нүүлгэн шилжүүлэх хугацаатай мэдэгдэх хуудас хүргүүлэн, нүүлгэн шилжүүлэх ажлыг зохион байгуулан ажиллаж байгаа болно.	Иргэний талд шийдвэрлэс эн өргөдөл

14	G230605102	ХУД-ийн дунд голын гүүрний ойролцоо мод бутанд хог ихээр хуримтлагдсан байна. Тус газрыг цэвэрлэж, цэцэрлэгт хүрээлэн байгуулж өгнө үү.	Тус гомдлын дагуу дунд гол дагуух цэвэрлэгээг 2023 оны 6 дугаар сарын 08-ны өдөр Эко бүлгийн иргэдээр цэвэрлүүлэн иргэнд утсаар мэдэгдсэн.	Иргэний талд шийдвэрлэсэн өргөдөл
15	G230613003	ХУД-ийн 13 дугаар хорооны иргэн. Хэсгийн ахлагч эмэгтэй нь түр оршин суугчдаа ямарваа үйлчилгээнд хамруулахгүй байна. Мэдээлэл өгөхгүй байна. Холбогдох газарт нь уламжилж өгнө үү. (бичлэг сонсох)	Гомдлын дагуу хорооны Засаг дарга болон зохион байгуулагчид иргэдэд төрийн үйлчилгээг хүртээмжтэй байдлаар үзүүлэх талаар анхааруулсныг 2023 оны 06 дугаар сарын 13-ны өдөр 95956786 дугаартай утсаар иргэнтэй холбогдож мэдэгдсэн тул хаав.	Иргэний талд шийдвэрлэсэн өргөдөл
16	G230623043	ХУД-ийн 6-р хорооны 189-р цэцэрлэгийн хогийн цэг нь манай байрны хүүхдийн тоглоомын талбайд байрлаж байна. Үүнээс болж орчны бохирдол үүсгэж байна. Тус хогийг өөр газар байрлуулж өгөхийг хүсэж байна. Миний саналыг холбогдох байгууллагад уламжилж өгнө үү.	Иргэний саналын дагуу судлахад тус 189 дүгээр цэцэрлэгийн талбайд хогийн савыг байршуулах өөр зай талбай байхгүй байна. Мөн цэцэрлэгийн хогийн сав анхнаасаа энэ байршилд байхаар төлөвлөгдсөн байна. Тус цэцэрлэгийн эрхлэгч Б.Бямбасүрэнд хогийн савыг битүүмжлэх, орчинд хог тарахгүй байх, ариутгал халдваргүйжүүлэлтийг тогтмол хийх тухай мэдэгдсэн.	Боломжгүй тухай хариу өгсөн өргөдөл
17	G231011011	ХУД-ийн 8 дугаар хорооны 118-р сургуулийн автобусны буудал дээр ТҮЦ тавьсан байна. Тус ТҮЦ-ийг өөр газар байрлуулж өгөх хэрэгтэй байна. ТҮЦ-үүдийг дагаад элдэв хүмүүсийн хөл хөдөлгөөн ихсэх тул өөр газарт нүүлгэж өгнө үү.	Дүүргийн Засаг даргын 2023 оны "Газрын зөрчил арилгаж, нүүлгэн шилжүүлэх арга хэмжээ авах тухай" А/545 дугаар захирамжийн хүрээнд нүүлгэн шилжүүлсэн.	Иргэний талд шийдвэрлэсэн өргөдөл
18	G231213054	ХУД-ийн 21 дүгээр хорооны иргэн. Яармагаас хотын төв рүү явсан төв зам дээр давс бодис цацаж халтиргаа гулгаанаас сэргийлэх арга хэмжээ авах шаардлагатай байна. Холбогдох газар нь уламжилж өгнө үү	Иргэний хүсэлтийн дагуу судлахад тус байршил нь яармагийн хороодын төв зам дагуу буюу Наадамчдын зам байна. Тус замыг Хот тохижилтын газар ОНӨААТҮГ хариуцдаг бөгөөд тус байгууллагад замын халтиргаа гулгааг арилгах давс цацах тухай шаардлага өгсөн. Шаардлагын дагуу хяналт тавин ажиллаж байна. Иргэнд энэ тухай утсаар мэдэгдэж, мэдээлэл өгсөн.	Иргэний талд шийдвэрлэсэн өргөдөл
19	G231225050	ХУД-ийн Яармагийн Хангардьд ордноос уруудаад Англи сургууль руу ордог замын мөсийг цэвэрлэж өгнө үү. Ус алдсан юм шиг мөс тогтож, зорчиход хүндрэлтэй байна. Уламжилж шийдэж өгнө үү	Тус гомдлын дагуу Хан-Уул тохижилт үйлчилгээний төвд мэдэгдэн замын мөсийг цэвэрлэх чиглэл өгсөн. Мөн 23-р хороо холбогдох сууц өмчлөгчдийн холбоо, орон сууцны конторт шаардага өгсөн.	Иргэний талд шийдвэрлэсэн өргөдөл

ДӨРӨВ. ӨРГӨДӨЛ ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТИЙГ ЭРЧИМЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР

1. Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийг эрчимжүүлэх чиглэлээр хэрэгжүүлэх 5 арга хэмжээтэй төлөвлөгөө боловсруулж 2023 оны 01 дүгээр сарын 03-ны өдөр Засаг даргын Тамгын газрын даргаар батлуулан ажиллаж байна. Төлөвлөгөөний хэрэгжилт 100% байна.

2. Өргөдөл, гомдлыг шийдвэрлэх явцад зөрчил гаргасан, хугацаа хэтрүүлэн хаасан Засаг даргын харьяа, дэргэдэх байгууллагуудад Засаг даргын Тамгын газрын даргын 2023.01.03 04/12, 2023.01.04 04/22, 04/23, 2023.01.10 04/60, 2023.03.09 04/350, 2023.04.10 03/606, 2023.05.18 03/847, 2023.06.20 03/1025, 2023.06.20 03/1026, 2023.06.20 03/1027, 2023.10.25 03/1720, 2023.10.27 03/1758, 03/1757, 03/1756, 03/1755, 03/1754, 03/1752, 03/1751, 03/1750, 03/1749, 03/1748, 03/1747, 03/1746, 03/1745, 03/1744, 03/1743, 03/1741 албан бичгүүдээр тус тус чиглэл хүргүүлэн ажиллаа.

3. Зөрчлийг бууруулаагүй Засаг даргын дэргэдэх 2 хэлтсийн дээд шатны байгууллагад Засаг даргын Тамгын газрын даргын 2023.05.03 03/736, 2023.05.03 03/737 дугаар албан бичгээр арга хэмжээ авах тухай хүргүүлж, ажиллаа.

4. Засаг даргын Тамгын газрын Хүнс худалдаа үйлчилгээний 1 мэргэжилтэн, 4 хорооны зохион байгуулагч 3 Засаг даргад "Нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд хандсан өргөдөл гомдлыг шийдвэрлэх журам"-ын дагуу арга хэмжээ авч ажиллах саналыг хүргүүлсэн.

ТАНИЛЦСАН:
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН
ХЭЛТСИЙН ДАРГА



З.БУЯНТ

БОЛОВСРУУЛСАН:
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
АЖИЛТАН



Ш.ГАНЦЭЦЭГ

ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР ИЛТГЭХ ХУУДАС

Дүүргийн төр, захиргааны байгууллагууд 2023 оны 4 дүгээр улиралд иргэдээс хүлээж авсан өргөдөл гомдол, шийдвэрлэлтийн тайланд хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн тухай


2023 оны 12 дугаар сарын 27-ны өдөр

Улаанбаатар хот


Дүүргийн хэмжээнд 2022 оны 12 дугаар сарын 25-нд 2418 гомдол бүртгэгдэж байсан бол энэ онд 2354 гомдол бүртгэгдэж 2,6 хувиар буурчээ. Үүнээс Засаг даргын Тамгын газарт 27,1%, Боловсролын хэлтэст 14,7%, Газар зохион байгуулалтын алба 14,6%, Хороодод 13,9%, нь бүртгэгдсэн бол Эрүүл мэндийн төв 7,1%, Цагдаагийн газар 6,9%, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс 6,4%, Нэгдсэн эмнэлэг 3,4%, Улсын бүртгэл 2,7%, Нийгмийн даатгалын хэлтэс 1,5%, Онцгой байдал, Замын цагдаа, Татварын хэлтэс, ОНӨААТҮГ нийт 1,5%, нь бүртгэгджээ.

Ирүүлсэн гомдлын 36,8 хувь нь төрийн байгууллагын үйл ажиллагаа, үйлчилгээ, зохицуулалтын талаар, 52,4%-ийг бусад асуудлууд, 10,8%-ийг нэр бүхий албан хаагчийн ёс зүй, зан харилцааны талаарх гомдол эзэлж байгаа юм.

ХАН-УУЛ ДҮҮРЭГТ 2023 ОНЫ 4 ДҮГЭЭР УЛИРАЛД БҮРТГЭГДСЭН
ГОМДЛЫН ЭЗЛЭХ ХУВЬ, БАЙГУУЛЛАГА, НЭГЖЭЭР




ХАН-УУЛ ДҮҮРЭГТ 2023 ОНД БҮРТГЭГДСЭН ГОМДЛЫН ТОО




Гомдол бүртгэгдсэн цаг хугацаагаар нь авч үзвэл Цагдаагийн газар, Боловсролын хэлтэс, Татварын хэлтэс, Улсын бүртгэл хэлтсийн гомдлын тоо буурсан хэдий ч Засаг даргын Тамгын газар, Хороод, Эрүүл мэндийн төв, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс зэрэг байгууллагуудын гомдлын тоо төдийлөн буурахгүй байна.

Гомдол, ерөнхий агуулга;



Ирүүлсэн гомдлын 6,4 хувь судлагдаж байгаа бөгөөд, 73,1 хувийг иргэдийн талд шийдвэрлэж 20,5 хувьд нь боломжгүй хариу өгчээ.

Гомдлын шийдвэрлэлт;




Засаг даргын Тамгын газарт ирүүлсэн 160 гомдлын 54 хувь нь Тохижилт нийтийн аж ахуйн хэлтэс, 31 хувь нь Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтэсд, 9 хувь нь Төрийн захиргааны удирдлагын хэлтэсд 3 хувь нь Төлөвлөлт, гүйцэтгэлийн удирдлагын хэлтэс, 2 хувь нь Хууль, эрх зүйн хэлтэс, 1 хувь нь Нийгмийн хөгжлийн хэлтэсд тус тус бүртгэгджээ.

Засаг даргын Тамгын газарт 2023 оны 4 дүгээр улиралд ирүүлсэн гомдлыг хэлтсүүдэд хуваарилагдсан байдлаар нь үзвэл;



Үүнээс үзэхэд тохижилт, нийтийн аж ахуй, худалдаа, үйлчилгээний салбарын асуудлаар ирүүлсэн санал хүсэлт нийт гомдлын зонхилох хувийг эзэлж байна.

Дөрөвдүгээр улиралд хороодод бүртгэгдсэн 82 гомдлын зонхилох хэсгийг тохижилт, хог орчны бохирдлын талаарх санал хүсэлтүүд эзэлжээ.





Дүүргийн хэмжээнд 4 дүгээр улирлын байдлаар Цагдаагийн газарт 42 гомдол бүртгэгдсэн нь нийт гомдлын 6,9 хувийг эзэлж байгаа юм. Ерөнхий агуулгаар нь авч үзвэл байгууллагын үйл ажиллагаа, хэргийн илрүүлэлттэй холбоотой 25, нэр бүхий албан хаагчийн ёс зүй, ажлын хариуцлагатай холбоотой 17 гомдол тус тус бүртгэгджээ.

Цагдаагийн газарт бүртгэгдсэн 42 гомдлыг агуулгаар нь авч үзвэл;



Шийдвэрлэлт	Иргэний талд
Иргэний талд	30
Боломжгүй	9
Судалж байгаа	3
Нийт	42

Хан-Уул дүүргийн Боловсролын хэлтэст 2023 оны 87 гомдол;



Шийдвэрлэлт	Иргэний талд
Судалж байгаа	1
Иргэний талд	66
Боломжгүй	20
Нийт	87

Хан-Уул дүүргийн Эрүүл мэндийн төвд ирсэн 42 гомдол;



Шийдвэрлэлт	Иргэний талд
Судалж байгаа	3
Иргэний талд	34
Боломжгүй	5
Нийт	42

Хан-Уул дүүргийн Нэгдсэн эмнэлэгт бүртгэгдсэн 20 гомдол;




Шийдвэрлэлт	Иргэний талд
Судалж байгаа	3
Иргэний талд	15
Боломжгүй	2
Нийт	20

Газар зохион байгуулалтын албанд бүртгэгдсэн 86 гомдол;



Шийдвэрлэлт	Иргэний талд
Судалж байгаа	9
Иргэний талд	49
Боломжгүй	28
Нийт	86

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэсд бүртгэгдсэн 38 гомдол;



Шийдвэрлэлт	Иргэний талд
Судалж байгаа	0
Иргэний талд	29
Боломжгүй	9
Нийт	38

Нийгмийн даатгалын хэлтэст бүртгэгдсэн 9 гомдол;




Шийдвэрлэлт	Иргэний талд
Судалж байгаа	1
Иргэний талд	8
Боломжгүй	0
Нийт	9

Зам засвар арчлалт ОНӨААТҮГ-т бүртгэгдсэн 1 гомдол;



Шийдвэрлэлт	Иргэний талд
Судалж байгаа	
Иргэний талд	1
Боломжгүй	
Нийт	1

Улсын бүртгэлийн хэлтэст бүртгэгдсэн 16 гомдол;



Шийдвэрлэлт	Иргэний талд
Судалж байгаа	1
Иргэний талд	14
Боломжгүй	1
Нийт	16

Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газарт бүртгэгдсэн 160 гомдол;



Шийдвэрлэлт	Иргэний талд
Судалж байгаа	10
Иргэний талд	119
Боломжгүй	31
Нийт	160

Хан-Уул дүүргийн хороодод бүртгэгдсэн 82 гомдол;



Шийдвэрлэлт	Иргэний талд
Судалж байгаа	6
Иргэний талд	62
Боломжгүй	14
Нийт	82

ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ ИРҮҮЛСЭН БАЙГУУЛЛАГУУД

Д/д	Хороо, хэлтэс, албадын нэр	Зөвлөмж хүргүүлсэн албан бичгийн дугаар	Зөвлөмжийн хэрэгжилт ирүүлсэн огноо, албан бичгийн дугаар
1	3 дугаар хороо	2023.04.10 06/571	2023.04.24 58
2	Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих төв		2023.04.25 58
3	18 дугаар хороо	2023.04.10 06/571	2023.04.26 64
4	Эрүүл мэндийн төв	2023.03.15 06/385	2023.05.10 №229
5	18 дугаар хороо		2023.05.25 76
6	Нийгмийн даатгалын хэлтэс		2023.05.19 379
7	Эко ахмадын сувилал ОНӨААТҮГ	2023.01.13 06/82	2023.06.14 42
8	Статистикийн хэлтэс	2023.07.06 03/1135	2023.12.05 59
9	Усан спорт, сургалтын төв ОНӨААТҮГ	2023.07.06 03/1135	2023.12.08 61

ДҮҮРГИЙН ХЭМЖЭЭНД 2023 ОНД БҮРТГЭГДСЭН ГОМДОЛ

Д/д	Байгууллагын нэр	Улирал				НИЙТ
		I	II	III	IV	
1	Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал		1			1
2	Засаг даргын Тамгын газар	89	106	151	160	506
3	Хороод	52	43	65	82	242
4	Цагдаагийн газар	69	88	111	42	310
5	Газар зохион байгуулалтын алба	39	60	96	86	281
6	Эрүүл мэндийн төв	45	57	54	42	198
7	Боловсролын хэлтэс	40	39	172	87	338
8	Нэгдсэн эмнэлэг	38	19	19	18	94
9	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс	35	68	31	38	172
10	Улсын бүртгэлийн хэлтэс	21	18	20	16	75
11	Нийгмийн даатгалын хэлтэс	13	15	9	9	46
12	Тохижилт, үйлчилгээний төв	9	3	2	3	17
13	Татварын хэлтэс	7	4	3	2	16
14	Туул тосгоны Эрүүл мэндийн төв	4	0		2	6
15	Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн хэлтэс	3	0	2		5
16	Ерөнхий боловсролын сургууль	2	0			2
17	Хан-Уул Агро ОНӨААТҮГ	2	1	1		4
18	Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих төв	1	0			1
19	Онцгой байдлын хэлтэс	1	3	13	2	19
20	Биеийн тамир, спортын хороо		1			1
21	Усан спорт сургалтын төв ОНӨУТҮГ	1	0			1
22	Эко хотын тээвэр ОНӨААТҮГ	1	0	4		5
23	Зам засвар арчлалт ОНӨААТҮГ		1	11	1	13
24	Нийтлэг үйлчилгээний алба ОНӨААТҮГ			1		1
НИЙТ		472	527	765	590	2354

ХАН-УУЛ ДҮҮРЭГТ 2023 ОНД БҮРТГЭГДСЭН НИЙТ ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ

Хан-Уул дүүрэг	Нийт өргөдөл		Хугацаанд шийдвэрлэсэн		Судлагдаж байгаа		Хугацаа хэтэрч шийдвэрлэсэн		Зөрчлийн тоон үзүүлэлт	
	2022 XII/25	2023 XII/25	2022 XII/25	2023 XII/25	2022 XII/25	2023 XII/25	2022 XII/25	2023 XII/25	2022 XII/25	2023 XII/25
ИТХ	9	3	6	1	1		2	2	62	68
Засаг даргын Тамгын газар	868	950	859	940	7	8	2	2	63	67
Харьяа хэлтэс, алба, тасаг	3826	3521	3703	3461	81	37	42	23	1174	575
Дүүргийн өмчит газрууд	51	72	49	69		2	2	1	158	50
Хороод	341	529	320	515	2	3	19	11	572	654
Эмнэлэг	534	670	522	662	5	8	7		265	125
Цэцэрлэг, сургууль	16	31	16	31					2	15
НИЙТ	5645	5776	5475	5679	96	58	74	39	2296	1554

ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

1. Нийт хэлтэс, албад удаа дараа давтагдаж буй санал, хүсэлт, гомдолд онцгой анхаарах, агуулгаар нь ангилж, тухайн байгууллагын шуурхай болон даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, таслан зогсоох үр дүнтэй арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлэн үр дүнг тооцох;

2. Байгууллагын албан хаагчид ээлжийн амралттай үед эсвэл түр хугацаагаар эзгүй үед албан ажлыг түр орлон гүйцэтгэж буй албан хаагчид хариуцлагатай хандаж, тухайн албан хаагчид ирсэн өргөдөл гомдол, албан бичгийг тогтмол шалгаж, хуулийн хугацаанд шийдвэрлэхэд анхаарах;

3. Байгууллагын удирдах албан тушаалтнууд ирсэн өргөдлийг өдөрт нь багтаан хүлээн авч шилжүүлэх, хүлээн авсан албан хаагч явцын тэмдэглэл хөтөлж хэвших нь зүйтэй.

ТАНИЛЦСАН:

ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА

О.ЭНХБАЯР

ХЯНАСАН:

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ХАВСРАН
ГҮЙЦЭТГЭГЧ

Л.ОТГОНБАЯР

ИЛТГЭХ ХУУДАС БИЧСЭН:

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН

Н.АЛДАРМАА